



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 4/14

Алтанбулаг

Бүх нийтийн ариутгал халдвартгуйжүүлэлтийн
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в", "е", 29.1.6 "а", "л", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.7, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 11.1.1, 11.1.8, Коронавируст халдвэр /Ковид -19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйл 13.2.3, Монгол улсын Стандарт MNS ISO/PAS45005.2021, Аймгийн Засаг даргын 2021 оны 01 сарын 22-ны өдрийн А/15 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлхий нийтэд хурдацтай тархаж байгаа /COVID-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор бүх нийтийн ариутгал халдвартгуйжүүлэлтийг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, аж ахуй нэгж байгууллага, айл өрх бүрийг хамруулан ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга /У.Энхбямба/-д даалгасугай.

2.Цаашид бүх нийтийн ариутгал халдвартгуйжүүлэлтийн ажлыг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 7 хоног бүрийн Баасан гарарт тогтмол зохион байгуулж хэвших, ариутгал халдвартгуйжүүлэлт хийгдээгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоо хүртэл арга хэмжээг авч ажиллахыг анхааруулсугай.

3.Нийтийн эзэмшлийн зам талбай болон 64 айл, 16 айлын орон сууцны орц, шатны хэсэг, ус түгээх цэгийн ариутгал хийх хуваарийг энэхүү захирамжийн хавсралтаар баталж, ариутгал халдвартгуйжүүлэлтийг сумын Эрүүл мэндийн төвийн дарга /У.Энхбямба/, "Бэхлэө хангай" МЭҮН-ийн захирал /Р.Булгаа/, "Бумбат-Өлгий" МЭҮН -ийн захирал /Л.Гантэмэр/ нар хариуцсан гүйцэтгэхийг тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын ХАА-н тасгийн Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Одмаа/, Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн /Д.Амартувшин/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ОТГОНЦОГТ

